



NATHOUSE
CREATIVE

E•BOOK

#29

И-МЭЙЛ МАРКЕТИНГ ХИЙХЭД ЗАЙЛШГҮЙ АНХААРАХ 13 ЗҮЙЛ



ЕРӨНХИЙ АГУУЛГА

- Оршил
- Хэн нэгний имэйл лист бүү ашигла.
- Хамгийн ихдээ л гурван төрлийн үсгийн фонт ашигла.
- Цахим гарын үсэг-Email Signature ашигла.
- Имэйл листээ тогтмол цэвэрлэж, шинэчлэж бай.
- Үндсэн мэссэж болоод "Үйлдэлд дуудах товч"-г эхэнд нь байрлуул.
- Тухайн хүний нэрийг нь мэндчилгээндээ багтаа.
- Имэйлийн өргөнийг 500-650 пиксел хэмжээнд барь.
- Гарчиг (subject), Үйлдэлд дуудах товчийг нь өөрчлөн А/В тэст хий.
- Имэйл нээж унших хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх өдөөгч ашигла.
- Имэйлийнхээ гарчиг (subject)-г нь сонирхолтой (гэхдээ товчхон) байлга.
- Автомат хариулагч ашигла.
- Имэйлээ газардах хуудаснуудтай нягт холбо.
- Туршиж үз.
- Дүгнэлт



ОРШИЛ

Интернэтийн эринд маркетерүүд, маркетингийн арга хэрэгслүүд ч хувьсан өөрчлөгдөж, хөгжсөөр.

Маркетерүүд олон төрлийн шинэ арга хэрэгслийг ашигладаг болсон ч, бага зардлаар өндөр өгөөжийг авч ирдэг имэйл маркетингийг орхигдуулж байгаа нь ажиглагддаг.

Тиймээс бид ямар ч салбарын байгууллагын хувьд үнэнч хэрэглэгч бий болгох, тогтмол харилцаа, холбоо тогтоох хамгийн шилдэг арга хэрэгслийн нэг болох имэйл маркетингийн талаарх нийтлэлийг энэ удаад хүргэж байна.





ХЭН НЭГНИЙ ИМЭЙЛ ЛИСТ БҮҮ АШИГЛА

Имэйл маркетингийн амжилт нээж унших хэрэглэгчдийн тооноос хамаардаг.

Харин танай хэрэглэгчдээс бүрдсэн биш харин өөр хэн нэгний имэйл лист авч ашиглаж байгаа тохиолдолд имэйл маркетингийн үр дүн тийм ч сайн байхгүй болов уу.



NATHOUSE
CREATIVE

E-BOOK

#29





Яг одоо Facebook Messenger Chatbot-той болох 10 шалтгаан

Хэрэв танд хэдхэн өдрийн дотор л хэрэглэгчийн үйлчилгээг тань сайжруулж, зардлыг бууруулж, орлогыг тань нэмэгдүүлэх цахим туслахтай болох боломж байна гэвэл та итгэх үү?

Яг ийн боломж олгох Facebook Messenger чатботтой эндээс танилц! Та Facebook Messenger чатботын талаар одоо л сонсож байгаа бол танай бизнес яг одоо хэрэгтэй зүйлсийн нэг энэ мөн гэдэгт итгэлтэй байж болно.

Харин та мэсэнжер болын талаар илүү их мэдээлэл авахаар сонирхож байгаа бол бид танд чатботоо өнөөдөр, яг одооноос эхлүүлэх хангийн чухал шалтгаануудыг танилцуулж байна.

[НИЙТЛЭЛ УНШИХ](#)

ХАМГИЙН ИХДЭЭ Л ГУРВАН ТӨРЛИЙН ҮСГИЙН ФОНТ АШИГЛА.

Таны илгээсэн имэйл хэр эмх цэгцтэй харагдана, төдий чинээ зорьсон үр дүнг тань авч ирнэ.

Мөн хоёр юмуу гурваас олон төрлийн фонт болон том, жижиг үсэг хольж ашиглах хэрэггүй.



Манай байгууллагын Facebook хөтөлгөөг чатбог зөвжүүлэхийн үүднээс саналыг дараах холбоосор авна уу: [Манай Бизнес-гүч болно Facebook Messenger Chatbot зөвжүүлэх нь](#).

Хүндэтгэсэн,
У. Анар-Эрдэнэ
Маркетер

Утас: 9419-4109

Натхауз Крейтив ХХК, #31, Arizona center, 1-р хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар. Утас: 976-76060708

Nathaus Creative, 31 Arizona Center, Chingeltai District, Ulaanbaatar, Mongolia

You may unsubscribe or change your contact details at any time.

ЦАХИМ ГАРЫН ҮСЭГ EMAIL SIGNATURE АШИГЛА.

Хэдийгээр 7 хоног бүрийн шинэ мэдээ илгээхдээ хувь хүний биш компанийн нэрийн өмнөөс харилцагчид руу илгээж байгаа ч уг имэйлийг хэн илгээж байгааг тодорхой илтгэсэн мэдээлэл оруулах ёстой.

Хүмүүс маркетингийн баг биш, харин хувь хүнээс ирсэн гэдгийг мэдвэл уг имэйлийг нээж, унших нь илүү байдаг. Тэгэхээр таны нэр тэдний анхаарлыг татах хэрэгсэл болдог юм шүү.



ИМЭЙЛ ЛИСТЭЭ ТОГТМОЛ ЦЭВЭРЛЭЖ, ШИНЭЧЛЭЖ БАЙ.

Танай имэйл листэнд байгаа зарим хүмүүс unsubscribe сонголтыг хийгээд листнээс хасагдахгүй ч илгээсэн имэйлийг хэзээ ч нээж үздэггүй байх нь бий.

Хэдийгээр олон хүнд имэйл илгээх нь зөв ч юм шиг гэхдээ илгээсэн имэйлийг нээж үздэггүй, оролцоо багатай хэрэглэгчдийг имэйл листдээ хадгалаад байх нь танай open rate буюу имэйл нээлтийн хувийг бууруулах аюултай.

Имэйл хэзээ ч нээж үздэггүй хүмүүс танай имэйл маркетингийг үзүүлэлтийг байгаагаас нь ч дор харагдуулж болно.

Тодорхой хугацаанд та имэйл жагсаалтаа эргэн харж, идэвхгүй хүмүүсийг хасч бай. Ингэснээр танай имэйл нээлтийн хувь (open rate)-г бодитой харуулахаас гадна хэрэгцээгүй хүмүүсийг цэвэрлэж өгдөг.



Та доорх 3 асуултанд хариулаад үз дээ.

- Та хэрэглэгчиддээ цаг тухайд нь хариу өгч амждаг уу?
- Дахин давтагдсан энгийн асуултанд хариу өгөхөд хэт их цаг зарцуулж байна уу?
- Өмнө холбогдсон хүмүүст хэрэгтэй мэдээллийг нь өгөх шаардлага гардаг уу?

Мөн эдгээр асуултанд ТИЙМ гэсэн хариу өгсөн бол хэрхэн шийдэж болохыг [та эндээс уншаарай.](#)

Хүндэтгэсэн,
У. Анар-Эрдэнэ
Маркетер
Утас: 9419-4109
Натхауз Крейтив ХХК, #31, Arizona center, 1-р хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар. Утас: 976-76060708

ФЕЙСБУК СУРТАЛЧИЛГАА ҮҮСГЭХ ГАРЫН АВЛАГА ЦАХИМ НОМ ҮНЭГҮЙ ТАТАЖ АВАХ

ҮНДСЭН МЭССЭЖ БОЛООД “ҮЙЛДЭЛД ДУУДАХ ТОВЧ”-Г ЭХЭНД НЬ БАЙРЛУУЛ.

Имэйлийнхээ эхэн хэсэгт байрлуулаагүйгээр уншигчдын 70% хүртэл хувь нь Үндсэн мессэж болоод "Үйлдэлд дуудах товч"-г харахгүй байх магадлалтай.

Түүнчлэн "Үйлдэлд дуудах товч"-г имэйлийнхээ өөр, өөр хэсэгт хамгийн багадаа 3 удаа байршуулах хэрэгтэй гэнэ шүү.



ТУХАЙН ХҮНИЙ НЭРИЙГ НЬ МЭНДЧИЛГЭЭНДЭЭ БАГТАА.

Имэйлээ нэрээр нь эхлүүлэх нь хүлээн авч буй хүний анхаарлыг тэр дор нь татдаг гэнэ.

Гэхдээ санаа зоволтгүй олон хүнд илгээх үед хүн бүрийн нэрийг гараар оруулах шаардлага гарахгүй.

Ихэнх имэйлийн маркетингийн хэрэгслүүд нь имэйлдээ хүлээн авагчийн нэрийг автоматаар оруулах боломжтой байдаг.

Өөрөөр хэлбэл имэйл лист дэх хүмүүсийн нэрийг имэйлдээ байрлуулан илгээх ажлыг таны ашиглаж буй имэйл маркетингийн апп хийчихдэг гэсэн үг.

Хүн болгон л зөвхөн өөрт нь зориулан илгээж буй мэт нэрийг нь дурьдсан имэйл хүлээн авна гэсэн үг.



Та доорх 3 асуултанд хариулаад үз дээ.

- Та хэрэглэгчиддээ цаг тухайд нь хариу өгч амждаг уу?
- Дахин давтагдсан энгийн асуултанд хариу өгөхөд хэт их цаг зарцуулж байна уу?
- Өмнө холбогдсон хүмүүст хэрэгтэй мэдээллийг нь өгөх шаардлага гардаг уу?

Мөн эдгээр асуултанд ТИЙМ гэсэн хариу өгсөн бол хэрхэн шийдэж болохыг [ТА ЭНДЭЭС УНШАВАРАЙ.](#)

Хүндэтгэсэн,
У. Анар-Эрдэнэ
Маркетер
Утас: 9419-4109
Натхауз Крейтив ХХК, #31, Arizona center, 1-р хороо, Чингалтэй дүүрэг,
Улаанбаатар. Утас: 976-76060708

ФЕЙСБҮҮК СУРТАЛЧИЛГАА ҮҮСГЭХ ГАРЫН АВЛАГА ЦАХИМ НОМ УНЭГҮЙ ТАТАЖ АВАХ
БОЛ [ЭНДЭЭС.](#)

Манай байгууллагын тогтмол зохион байгуулагд Социал медиа маркетинг, Дижитал
маркетингийн сургалтын талаарх мэдээллийг [ЭНДЭЭС.](#)

Мөн манай маркетингийн үйлчилгээний багцтай танилцах бол [ЭНДЭЭС.](#)

Social Media Thursday Facebook Live нэвтрүүлгийн дугааруудыг [ЭНДЭЭС.](#)

P.S. Бидний бэлтгэсэн шинэ нийтлэлийг цаг тухайд нь хүлээж авч байхын тулд
манай info@nathouse.mn хаягийг өөрийн contacts list-д нэмээрэй ;).

650

ИМЭЙЛИЙН ӨРГӨНИЙГ 500-650 ПИКСЕЛ ХЭМЖЭЭНД БАРЬ.

Хэрэв таны имэйлийн өргөн нь 650 пикселээс их бол хүмүүсийн гар утасны дэлгэц дээр багтахгүй байх магадлалтай.

Тэгэхээр нь имэйлийн өргөн үр дүнг дээшлүүлэх тун чухал зүйл болно шүү.



ГАРЧИГ (SUBJECT), ҮЙЛДЭЛД ДУУДАХ ТОВЧИЙГ НЬ ӨӨРЧЛӨН А/В ТЭСТ ХИЙ.

Танай open rate-нээлтийн хувь, click-through rate-холбоос дээр дарах үзүүлэлтүүд тийм ч сайнгүй, өсгөх оролдлогууд амжилтгүй болоод байгаа бол юу болохгүй байгааг туршилтаар илрүүлэх боломжтой.

А/В тестийн аргачлал нь имэйл маркетингт ч биш дижитал маркетингийн бүхий л салбарт контентын үр дүнг сайжруулахад ашигладаг.

Имэйл маркетингийн хувьд А/В тестийг хийхдээ имэйл хүлээн авагчдаа хоёр хуваагаад А хэсэгт нь ердийн өмнө илгээдэг хувилбарыг харин В хэсэгт өөрчлөлт хийсэн хувилбарыг илгээдэг.

Ингэснээр энэ өөрчлөлт өмнөхөөс илүү үр дүнтэй байж чадах эсэхийг туршдаг. Нээлтийн хувийг өсгөж, холбоо дээр даралтыг нэмэгдүүлж байгаа бол дараа, дараагийн имэйлээ шинэчлэсэн загвартайгаар илгээж болно гэсэн үг.



ИМЭЙЛ НЭЭЖ УНШИХ ХЭРЭГЛЭГЧДИЙН ТООГ НЭМЭГДҮҮЛЭХ ӨДӨӨГЧ АШИГЛА.

Имэйлийнхээ гарчиг (Subject)-т уг имэйлийг нээж үзэх сэдэл төрүүлэх үг, хэллэг ашигласнаар нээлтийн хувийг 50% хүртэл нэмэгдүүлэх боломжтой байдаг гэнэ.

"Зөвхөн өнөөдөр 30% хүртэл хямдрал", "Шинээр нэмэгдсэн цахим номнууд: Үнэгүй татаж авахаар" гэх мэт урамшуулал, сэдэл агуулсан гарчиг оруул.

Гэхдээ үнэ, хямдрал гэх мэт борлуулалтын имэйлээр бөмбөгдөхөөс зайлсхийх хэрэгтэй.

Мэдээж тухайн хэрэглэгч худалдан авалтын замналын аль хэсэгт байгаагаас хамааран нь илгээх мэдээллийн агуулга өөрчлөгдөнө шүү дээ.



- ☆ Facebook Ads Team **Inbox** Your ad is approved - Account: nathouse creative Campaign: SS Garden terraco Post Ad Set: ...
- ☆ me 3 Сайн байна уу? "Натхауз Крейтив" ХХК-аас холбогдож байна. - Сайн байна уу? "Натхауз Крейти...
X chatbot menu ... **PDF** Chatbot-үйлчи...
- ☆ Facebook Ads Team 2 **Inbox** Your ads are approved - Ad: Nathouse Creative Social Me... Account: nathouse creative Camp...
- ☆ **Nathouse Creative L.** **Inbox** Социал медиа маркетингийн стратеги хэрхэн боловсруулах вэ? - Социал ме...   
- ☆ Slack **Inbox** [Slack] Notifications from the nathouse workspace for August 9th, 2019 at 1:30 PM - from the...
- ☆ Facebook Ads Team **Inbox** Your ad is approved - Account: nathouse creative Campaign: SSGarden live 08/08 Ad Set: SS...
- ☆ Slack **Inbox** [Slack] Notifications from the nathouse workspace for August 8th, 2019 at 2:15 PM - from th...
- ☆ Baatarchuluun Chagn. **Inbox** Худалдан авагчийн персона: Маркетинг хэрхэн үр дүнтэй ашиглах вэ? - Nathouse Week...

ИМЭЙЛИЙНХЭЭ ГАРЧИГ (SUBJECT)-Г НЬ СОНИРХОЛТОЙ (ГЭХДЭЭ ТОВЧХОН) БАЙЛГА.

Имэйлийн гарчиг нь 30-аас 50 тэмдэгтэд багтаж байхаар тооц. Хэт урт бол гарчигийн эхний хэсгийг л үлдээж, бусдыг нь харуулахгүй байхаар таслагдсан харагдуулдаг.

Мөн гарчиг (subject) уншигчдыг имэйлээ нээснээр юу хүлээн авч болохыг илтгэсэн байх хэрэгтэй.



Танд харилцагчдын түүхээсээ товч танилцуулахыг зөвшөөрнө үү.

Өдөр бүр хэрэглэгчдээс ирдэг 100, 100 асуултанд тэр дор нь хариу өгөхийн тулд манай нэг харилцагч зөвхөн Facebook постын коммент, мэссэнжерийн асуултанд хариу өгдөг ажилтан тусад нь ажиллуулдаг байсан.

Харин одоо Facebook Messenger Chatbot-той болсноор 24 цагийн турш, амралтгүй, алдаагүй хариу өгдөг ЦАХИМ туслахтай болсон. Энэ цахим туслах нь Facebook мэссэнжерээр ирсэн **асуулт** бүрт хариуг нь тэр дор нь өгөхөөс гадна постын **коммент** бүрт мөн адил хариу өгдөг. Түүнээс гадна вэб дээрх шинэ мэдээ, урамшууллын мэдээллээ ч мэссэжээр хэрэглэгчдэдээ хүргэх нь хамгийн ангийн функцуудынх нь нэг.

Өмнө нь уг ажлыг хариуцдаг байсан ажилтан өөр, илүү бүтээлч ажилд анхаарал хандуулах боломж гарсан. Энэ бол манай харилцагчдын ердийн нэг жишээ.

Та манай эдгээр харилцагчдын нэгнийх нь мэссэнжерт холбогдож туршиж үзэхийг хүсвэл дараах холбоосоор хандаарай. <https://chatfuel.com/bot/iphonecenter/m>

Манай байгууллагын Facebook мэссэнжер чатбот хөгжүүлэлтийн үнийн саналыг дараах холбоосоор авна үү  [Танай бизнес тус болох Facebook Messenger Chatbot хөгжүүлэх нь.](#)

Хүндэтгэсэн,
У. Анар-Эрдэнэ
Маркетер
Утас: 9419-4109
Нагсауз Крейтв ХХК, #31, Arizona center, 1-р хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар. Утас: 976-76060708

ИМЭЙЛЭЭ ГАЗАРДАХ ХУУДАСНУУДАЙ НЯГТ ХОЛБО.

Таны газардах хуудасны гарчиг, агуулга, харагдах байдал, өнгө төрх имэйлийнхтэй тохирч байх ёстой.

Түүнчлэн газардах хуудас дээрээ хаанаас, хэн хандаж байгаа, ямар үйлдэл хийж байгааг бүртгэх хэрэгсэл ашиглаарай. Энэ нь дараа, дараагийн имэйл маркетингийн ажлын үр дүнг дээшлүүлэхэд хэрэг болно.



Сайн байна уу Анаг!

Сошиал медиа маркетингийн контент төлөвлөгөөний загвар файл татаж авсанд баярлалаа.
Энд:

- 2019 оны календарийг долоо хоног бүрээр нь зааглаж, гариг тус бүрийг тэмдэглэн, бүх нийтээр амрах болон онцлох өдрүүдийг багтаасан;
- Төлөвлөгөөнд заавал тусгах ёстой үзүүлэлтийг бодит жишээ, тайлбарын хамт оруулсан;
- Төлөвлөгөөний гүйцэтгэл, тайланд багтах үзүүлэлт мөн багтсан;

нь МАРКЕТЕР таны өдөр тутмын ажилд тус болно гэдэгт итгэлтэй байна.

Сошиал медиа маркетингийн контент төлөвлөгөөний загвар файлыг
ТАТАЖ АВАХ товч дараарай.

ТАТАЖ АВАХ

Та энэхүү контент төлөвлөгөөний загварыг хэрхэн ашиглах талаар эхо оношилгоо, эмэгтэйчүүдийн [Ирээдүй эмнэлгийн бодит жишээн дээр дэлгэрэнгүй тайлбарласан нийтлэлийг мөн эндээс хүлээн аваарай](#). Тангыг уг төлөвлөгөөг илүү үр дүнтэй ашиглахад тус болно гэдэгт итгэлтэй байна.

АВТОМАТ ХАРИУЛАГЧ АШИГЛА.

Танай вэб дээрх бүртгэлийн хуудсаар имэйлээ бүртгүүлсэн тохиолдолд бүртгэл баталгаажсан талаарх мэдээлэл эсвэл татаж авах материалын холбоосыг агуулсан имэйлийг автоматаар илгээхээр тохируул.





ТУРШИЖ ҮЗ.

Имэйлээ нийтэд илгээхээсээ өмнө ажлыхандаа эсвэл бизнесийн хамтрагчдаа илгээ.

Имэйлийн гол зорилго юу болох талаар тэр дор нь мэдэж авч чадаж байна уу? Өөрчлөх, сайжруулах зүйл юу байна тэднээс хариу ав.



NATHOUSE
CREATIVE

E-BOOK

#29



ДУГНЭЛТ

Өнөө үед хэрэглэгчдийн анхаарал татах маркетингийн шинэ арга хэрэгслүүд бий болсон гэдэгтэй санал нэг байна. Гэхдээ имэйл маркетинг бол жинхэнэ цаг хугацааны шалгуурыг давж гарч чадсан, үр дүнтэй арга гэдгийг бид өөрсдийн туршлага дээрээс маш сайн мэдэж авсан.

Танд ч бас тийм үр дүн авч ирнэ гэдэгт итгэлтэй байна.





**NATHOUSE
CREATIVE**

E-BOOK

Та социал медиа маркетингийн талаар хамгийн сонирхолтой, хэрэгтэй нийтлэл унших болон манай үйлчилгээ, сургалтын мэдээлэл авахыг хүсэж байвал доорх хаягаар холбогдоорой



www.nathouse.mn
info@nathouse.mn



(976) 7606 0708
(976) 9111 9110